

**УВС АЙМАГТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ  
ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР  
2017-2021 он**

**НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улсын Их хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болон хөгжих зорилтыг тавьсан бөгөөд 2016-аас 2020 онд Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэхээр тодорхойлсон байна.

Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 324 дүгээр тогтоолоор Монгол Улсын “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчин бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилт тавин, үндэсний зан заншил, уламжлал, түүх соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгасан.

Увс аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх “Манай Увс” үйл ажиллагааны хөтөлбөрийн Эдийн засгийн хөгжлийн нэг үзүүлэлт нь аялал жуулчлалын хөгжил байхаар тусгагдсан. Иймээс аймаг, сумын онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлэх, аялал жуулчлалын материаллаг баазыг бэхжүүлэх, менежментийг боловсронгуй болгох, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх зэрэг шаардлагыг үндэслэн Увс аймгийн “Аялал жуулчлалын дэд хөтөлбөр”-ийг боловсрууллаа.

**1.1. Увс аймгийн нөөц**

1925 онд Дөрвөд далай хаан, Зоригт хааны аймгийг нэгтгэж Чандмань уулын аймгийг байгуулж, 1931 оны 2 дугаар сарын 6-нд Увс аймгийн хилийн заагийг тогтоосноор Увс аймгийн засаг захиргааны хуваарь үүссэн. Аймгийн төв нь Улаангом сум д.т.д 939 метр өндөрт оршдог, засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум, 93 багтай, 81.4 мянган хүн амтай. Монгол улсын баруун хойморт Их нууруудын хотгорын хойд хэсэгт өргөрөгийн дагуу сунаж тогтсон 69,6 мянган ам дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, Баян-Өлгий, Ховд, Завхан аймаг, ОХУ-тай хиллэдэг. Нийслэл Улаанбаатар хотоос 1336 километр алслагдсан.

Увс аймаг нь төв азийн унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, хангай, говь цөл хосолсон үзэсгэлэнт сүрлэг байгаль, олон ястны өвөрмөц ахуй, зан заншил, түүх соёлын дурсгал, эрдэс баялаг

арвинтай аялал жуулчлал хөгжүүлэх боломжтойгоос гадна газрын хэвлийн нөөц нь бараг хөндөгдөөгүй, газар тариалан эрхлэх соёл уламжлалтай, байгаль цаг уурын **ЭРС ТЭС УУР АМЬСГАЛ** бүхий нөхцөлд дасан зохицсон мал сүрэг, ажилсаг, хөдөлмөрч, оюунлаг иргэдтэй, ажиллах хүчний нөөц сайтай, ОХУ-тай хатуу хүчилттай авто замаар холбогдсон зэрэг олон давуу талууд нь орон нутгийн онцлог бүхий тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтойг харуулж байна.

Тухайлбал, Увс, Хяргас нуур түүний эргэн тойрны говийн бүс, Хархираа, Түргэн, Ханхөхийн өндөр уулс бүхий говь, цөлөөс өндөр уулын мөнх цас, мөсөн гол хүртэлх төв Азийн гадагш урсгалгүй ай савын босоо бүслүүрийн бүхий л хэв шинжийг тусгасан ландшафт газарзүйн өвөрмөц тогтоц бүхий “Төв Азийн эталон” нутаг юм. Хамгийн нам цэг нь д.т.д 758,9 метрт буй Увс нуурын дархан цаазат газар бөгөөд хамгийн өндөр цэг нь д.т.д 4037 метрт өргөгдсөн Хархираан уулсын Мөст оргил юм.

Ийнхүү мөнх цаст өндөр уулсын бүслүүрээс ойт хээр, говь цөлийн бүсэд шилжих байгалийн олон бүс бүслүүрийг хамран орших нь аялал жуулчлалын олон төрөл хэлбэрийг нэгэн зэрэг хөгжүүлэх давуу талтай бөгөөд нэн ялангуяа Хархираа, Түргэний салбар уулсын 31 цаст оргилууд нь адал явдалт, спорт аялал сонирхогчид болон уулчдын сонирхлыг ихээр татаж байна.

### **1.2.Түүх соёлын нөөц**

2015-2016 оны түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогоор аймгийн нутаг дэвсгэрт эртний түүх соёлын дурсгалт зүйл болох хүн чулуу 161, буган хөшөө 33, хадны сүг зураг 77, бичиг тэмдэгт хөшөө 10, гэрэлт хөшөө 1, хүн хөшөө 163, хиргисүүр 1334, булш 275, тамга тэмдэгтэй хөшөө 1, палеонтологийн дурсгал 1, амьтны дүрстэй хөшөө 1, оромж сууц агуй 4, түүнчлэн Өмнөговь сумын Улиастайн шилд мөн Давстын Торхилог багийн нутагт эртний хотын үлдэгдэл, олон мянган хиргисүүр, цөөнгүй тооны эртний сүм хийдийн үлдэгдэл, туурь бүртгэгдсэн.

Улаангомын Чандмань уулын археологийн олдвор нь эртний түүх соёлын нандин өвд тооцогддог. Аймгийн музейд нийт 2700 дэсийн 5714 ширхэг үзмэр байгаагийн 10 гаруй нь хосгүй үнэт дурсгал юм.

Аймгийн хэмжээнд нийт 101 цэгт 41500 гаруй хадны сүг зураг тэмдэглэгдсэнээс түүхийн хувьд илүү ач холбогдол бүхий 13 хадны зураг бий. Он цагийн хувьд Хүрэл зэвсгийн үед хамаарагдах 5, чулуун зэвсгийн үед хамаарагдах 4, төмөр зэвсгийн үеийн 3, Хүннүгийн үед хамаарагдах ховор олдворууд, дундад зууны үеийн 1 хадны зураг байна.

### **1.3 Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал**


Сүүлийн жилүүдэд Увс нутгийг сонирхон ирэх гадаад, дотоодын аялагч жуулчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Тухайлбал, байгалийн аялал, Явган /морин аялал, Түүх соёлын аялал, Шувуу ажиглах аялал, Ан агнуурын аялал, Уулын аялал, Усан аялал, Нүүдэлчдийн амьдралтай танилцах болон угсаатны аяллаар голчлон аялагч жуулчид ирж аялаж байна. Аяллын гол маршрут нь Хархираа Түргэний уулс, Увс нуурын ай сав газрууд, Хяргас нуурын байгалийн цогцолборт газруудыг хамарч байна.

Хойд хөрш орон болох ОХУ-тай хатуу хүчилттай замаар холбогдсон, харилцан визгүй зорчих болсонтой холбоотойгоор сүүлийн жилүүдэд ОХУ-аас ирэх аялагчид, худалдаа наймаа эрхлэгчдийн тоо өсөн нэмэгдэж байгаа нь цаашид аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүтээгдэхүүн үйлчилгээ, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

**Увс аймгийн аялал жуулчлалын суурь үзүүлэлтүүд:**

1.а/ Хилийн боомтоор нэвтэрсэн байдал

	2012	2013	2014	2015	2016	2017 –ны 8 сар
Гадаад /61730/	9300	10500	15400	26751	35108	32015
Монгол /50088/	8300	9488	13500	18800	19300	17500



б/ Ирж буй гадаадын жуулчид (Зочид буудал, жуулчны баазаар буудалласан гадаадын аялагчдын тоо)

	2012	2013	2014	2015	2016	2017 –ны 8 сар
Байршуулах хэрэгсэлд байрласан гадаад жуулчид	1770	1595	1511	1680	2230	4100



Жич: 2012-2016 оны судалгаанд ОХУ-ын Тувагийн иргэдийн тоон мэдээлэл оруулдаггүй байсан.

Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд

№	Үйлчилгээний чиглэл	ААН-ийн тоо	Байнгын ажлын байр	Улирлын чанартай ажлын байр
1	Жуулчны бааз	8	30	50
2	Амралтын газар	3	7	18
3	Рашаан сувилал	3	6	6
4	Гэр бааз	4	4	10
5	Зочид буудал	7	35	45
6	Гэст хаус/ дэн буудал	2	2	2
7	GUIDE, хөтөч тайлбарлагч			10-15
8	Тогооч			10-20
9	Тээвэр зууч			5-10
	Нийт	27	84	145


Ресторан, зоогийн газар, кафе бусад үйлчилгээ

№	Үйлчилгээний төрөл	Хүчин чадал /суудлын тоо/	ААН-ийн тоо
1	Ресторан	100-250	5
2	Ресторан, Зоогийн газар	50-80	5
3	Паб, кафе	35-45	4




1. Байршуулах хэрэгслийн орны тоо

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017 – ны 8 сар
байршуулах хэрэгслийн орны тоо	245	285	685	815	1000	1050	1300	1350	1430



2. Хоол ундааны газрын суудлын тоо



Увс аймагт 1993 оны үеэс эхлэн аялал жуулчлалын компаниуд жуулчны бааз байгуулан, үйл ажиллагаагаа явуулж ирсэн

#### Увс аймагт зохион байгуулагдаж буй эвент арга хэмжээ

- Ойрад түмэн язгуур урлагийн ОУ-ын наадам
- Тэмээний баяр /Мөсний баяр –Хяргас нуур 03 дугаар сарын эхний 7 хоног/
- Увс нуур цомын барилдаан /Бух ноолдан 09 сарын 15-20 хооронд/
- Чацарганы баяр /09 сарын сүүлийн 7 хоногт/
- Увс нуурын ханш нээх баяр /Цөн түрэх, Шувууны баяр 05 сарын 10-15/

#### 1.3.1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС НУТГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Увс аймагт хөгжүүлэх боломжтой аяллын төрлүүд

Аялал рекреацийн бүсүүд	Түүх соёлын дурсгалт газрууд	Байгалийн үзэсгэлэнт газрууд, ховор ба нэн ховор ургамал, ан амьтад	Цаашид хөгжүүлэх боломжтой ерөнхий ба тусгай сонирхолын аяллын төрлүүд
Аяллын чадавхи өндөртэй бүс нутаг (Тариалан,Сагил, Давст, Түргэн, Улаангом ) сумдын нутаг	Халхайтын дэнжийн хүн чулуун хөшөө, Бор нурганы хүн чулуун хөшөө, Мөнгөт цахирын хадны зураг, Тэхтийн давааны хадны зураг, Харлаг бээсийн сүм, Чандманы дурсгал,Хар ямаат, Можоогийн	Увс нуурын ДЦГ, Цагаан шувуутын ДЦГ, Хархираа- Түргэний уул, Үүрэг нуур Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн нэн ховор, ховор ан амьтдаас зэгсний гахай, Хүдэр, буга, согоо, Азийн минж, хуруут хун, цасч дэглий, хээрийн галуу	<ul style="list-style-type: none"> <li>➤ <u>Нэн ховор амьтан түүний үл мөрөөр аялах аялал:</u> Хархираа, Түргэний уул, Ямаат уул, Цагаан шувуут уулын нутгаар зэрлэг байгалийн “хатан хаан” ирвэсийн хаяг, бумбаа үлдээсэн үл мөрөөр аялах төдийгүй аргаль, янгирыг ажиглан харах боломжтой.</li> <li>➤ <u>Усан спорт аялал</u></li> <li>➤ Увс, Хяргас, Ачит, Үүрэг, Айраг, Дөрөө, Баян нуурууд, Ховд, Тэс, Хархираа, Түргэн, Шивэр, Нарийн, Хангилцаг зэрэг голуудаар завиар аялах</li> </ul>

	<p>хадны зураг, Сартагтай хааны түүхт хад,Мянганы хөндийн дурсгалт газрууд</p>		<p>боломжтой</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ <u>Уулын аялал:</u> Хархираа, Түргэний уулс, Цагаан шувуут, Цагаан Дэглийн мөнх цаст өндөр оргилуудад авирах</li> <li>➤ <u>Шувуу ажиглах аялал:</u> Увс, Үүрэг нууруудад усны шувуудын цуглааныг ажиглах аяллыг 5-6 саруудад зохион байгуулах боломжтой.</li> <li>➤ <u>Цэцэг ажиглах аялал</u> Хархираа, Түргэний уулс, Хан хөхийн нурууны орчмын газар нутаг нь явган аяллын хувьд хамгийн тохиромжтой байгалийн иж бүрдэл бүрдсэн экзотик шинжтэй.</li> <li>➤ <u>Нүүдэлчдийн амьдралтай танилцах болон угсаатны аялал:</u> Баяд, дөрвөд, халх, хотон ястан малчин айлд зочлон нүүдэлчин ахуйтай танилцах, соёл зан заншил, нутгийн зан үйлд суралцах, хоол цай амтлах, “Нүүдэлчдийн хотхон” байгуулах зэрэг сонирхолтой идэвхитэй аяллыг нутгийн иргэд, малчдын нөхөрлөлд түшиглэн зохион байгуулах боломжтой.</li> <li>➤ <u>Түүх соёлын аялал</u> Сагил, Давст сумын чиглэлд илүүтэй хөгжүүлэх боломжтой.</li> <li>➤ <u>Байгалийн аялал</u> Дэлхийн өвд бүртгэгдсэн байгалийн үзэсгэлэнт нутаг харьцангуй богино зайнд байгалийн бүс бүслүүрийн бүхий л шинжийг харах</li> <li>➤ <u>Амралт сувилгааны аялал</u></li> <li>➤ <u>Эрдэм шинжилгээ судалгааны аялал</u></li> <li>➤ <u>Бартаат замын буюу авто аялал</u></li> <li>➤ <u>ФОТО АЯЛАЛ-ФОТО САФАРИ</u></li> </ul>
<p>Аяллын чадавхи дунд бүс нутаг (Ховд, Цагаан хайрхан, Баруун түрүүн, Бөхмөрөн, Малчин, Хяргас, Наранбулаг, Өндөрхангай сумд)</p>	<p>Хар Цагаан усны хадны зураг, Улаан толгойн дурсгал, Жаажаагийн хөтөлийн хүн чулуун хөшөө, Наранбулагийн хадны зураг</p>	<p>Гоожуурын хүрхэрээ, Ханхөхий-Хяргас нуурын БЦГ -А-Б, Хархираа-Түргэний ДЦГ, Алтан элс ДЦГ, Увс нуурын ДЦГ, Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн нэн ховор, ховор</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ <u>Ан агнуурын аялал:</u> Ховдын Отор, Түргэний Шаварт, Атар, Сагил, Бөхмөрөний нутаг дамнасан “Гулзат” ОНТХГ, Ханхөхийн салбар уулс орчмоос буга, тэх, угалз, бор гөрөөс, гахай зэрэг нэн ховор амьтныг тусгай зөвшөөрлөөр агнаж болно. Хяргас, Айраг, Ачит, Үүрэг, Дөрөө зэрэг нуураас загас барих боломжтой.</li> <li>➤ <u>Шувуу ажиглах аялал</u></li> </ul>

		ургамал, ан амьтдаас Янгир, ирвэс, хойлог, зэгсний гахай, Азийн минж, хуруут хун, цасч тэглэй, хээрийн галуу вансэмбэрүү, цагаан уул цэцэг, төрөл бүрийн эмийн ургамал, мөнх цаст өндөр уулс	Хяргас нуур, Хяргас Айрагийн хоолой, Үүрэг нуур зэрэгт усны шувуудын цуглааныг ажиглах аяллыг 5-6 саруудад зохион байгуулах боломжтой. ➤ <u>Усан спорт аялал</u> ➤ <u>Морь, тэмээн аялал</u> ➤ <u>Угсаатны аялал</u> ➤ <u>Түүх соёлын аялал</u> ➤ <u>Амралт сувилалын аялал жуулчлал</u> ➤ <u>ФОТО АЯЛАЛ-ФОТО САФАРИ</u>
Аяллын чадавхи султай бүс нутаг (Завхан, Өмнөговь, Тэс, Зүүнговь, Зүүнхангай, Өлгий сумд)	Шар булгийн хадны зураг, Зураагийн улаан хадны зосон зураг, Шар булгийн онцын хадны зураг	Ханхөхий-Хяргас нуур-А, хэцүү хад, Увс нуурын ДЦГ, Тэсийн гол-БНГ, Ханхөхий-Хяргас нуур-Б, Таван цонж	➤ <u>Явган ба морин, тэмээн аялал:</u> Баян нуур, Бөөрөг дэлийн элсний чиглэлд явган ба морьт, тэмээн аяллыг тодорхой зам маршрутын дагуу нутгийн иргэд, малчдын нөхөрлөлд түшиглэн зохион байгуулах боломжтой. ➤ <u>Түүх соёлын аялал</u> ➤ <u>Угсаатны аялал</u> ➤ <u>ФОТО АЯЛАЛ-ФОТО САФАРИ</u>

Эдгээр аяллыг дагнасан хэлбэрээр хөгжүүлэхээс гадна хосолсон байдлаар хэрэгжүүлэх нь ач холбогдолтой юм.

## ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2017 оноос 2021 он хүртэл хэрэгжүүлнэ.

### 1- р үе шат: 2017 – 2019 он

Үе шатны зорилго: “Аймгийн аялал жуулчлалын салбарын бүтэц, зохион байгуулалт, маркетингийг тогтвортой байлгаж, жуулчны бааз, үйлчилгээний байгууллагуудын материаллаг хангамж, боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, гадаад, дотоодын үзэсгэлэн яармагт оролцож байгалийн үзэсгэлэнт байдал болон үндэстэн ястны ахуй амьдрал, ёс заншлыг сурталчлах, аялагч жуулчдыг татах

### 2- р үе шат: 2020 – 2021 он

Үе шатны зорилго: Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ард иргэдийн аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх



## **ГУРАВ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **Зорилго**

***“Дэлхийн өв нутаг болон түүх соёлын дурсгалыг хадгалан хамгаалж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжил, байгаль орчны боловсролыг дээшлүүлэх, ард иргэдэд санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг бий болгоход оршино”***

### **Зорилтууд**

#### ***3.1. Байгаль, түүх соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, аялал жуулчлалын төв байгуулж хөгжүүлэх***

##### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- а/ Аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасгах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх
- б/ Адал явдалт спорт аяллыг хөгжүүлэх
- в/ Аймгийн төвд болон нисэх онгоцны буудалд мэдээллийн төв байгуулж гадаад, дотоодын жуулчдыг мэдээллээр хангах, мэдээллийн сан бүрдүүлэх
- г/ Хөрш орнуудтай хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх
- д/ Хөрш зэргэлдээ улс орнуудад “Увс аймгийн өдөр” арга хэмжээг зохион байгуулах
- е/ Түүх соёлын өвийн судалгаа, шинжилгээг нэмэгдүүлэх, хадгалалт хамгаалалтын асуудлыг сайжруулах, соёлын өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэх

#### ***3.2 Баруун Монголын өв соёлыг сурталчлан таниулах, эвент арга хэмжээ болгон хөгжүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж тэдний амьжиргааг дээшлүүлэх***

##### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- а/ “Баруун монголын язгуур урлагийн наадам”, “Чацарганы баяр”, “Увс нуур цом”-ын барилдаан, Ирвэсийн баяр зэргийг зохион байгуулж үндэсний арга хэмжээ болгох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэх
- б/ Нутгийн иргэдэд түшиглэсэн Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх
- в/ Орон нутгийн онцлогийг харуулсан бүтээгдэхүүний дизайн, үйлдвэрлэл, менежментийг сайжруулах
- г/ Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах малчин өрх, жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, орлого нэмэгдүүлэх

#### ***3.3. Аялал жуулчлалын маркетинг сурталчилгааны ажлыг хөгжүүлэх, орон нутгийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, сайжруулах***

##### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- а/ Жил бүр Улаанбаатар хотноо болон хөрш зэргэлдээ орнуудад зохион байгуулагддаг аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт оролцож сурталчлах
- б/ Аймгийн аялал жуулчлалын цахим хуудсыг сайжруулан хөгжүүлэх, аймаг орон нутгийг танилцуулсан гарын авлага, хөтөч номыг англи, орос, хятад хэлээр гаргах
- в/ Эвент арга хэмжээнүүдийг өндөр түвшинд уламжлал болгон зохион байгуулах
- г/ Гадаад болон дотоодын аялагч нарт аймгийн аялал жуулчлалын мэдээллийг бүрэн илэрхийлж чадах хэмжээний гар утасны аппликэйшин болон платформ бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх
- д/ Аймгийн байгалийн үзэсгэлэнт газар болон түүх соёлын дурсгалыг харуулсан баримтат кино хийх, фото зураг авах

е/ Сум бүрт жуулчдын аюулгүй байдлыг хангах зөвлөлийг байгуулах, эрүүл мэндийн төвүүдэд мэдээллийн самбар байршуулах

ё/ Жуулчдын даатгалын үйлчилгээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

### **3.4. Хүний нөөцийг чадавхжуулах, үйлчилгээний байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

а/ Аялал жуулчлалын үйлчилгээний салбарын ажилчдыг үе шаттайгаар чадавхжуулах, аялал жуулчлалын аймгийн нэгдсэн зөвлөгөөнийг 2 жил тутам зохион байгуулах

б/ Улаангом Политехник коллежийг түшиглэн мэргэжлийн боловсон хүчнийг чанартай бэлтгэх

в/ Үйлчилгээний салбарын ажилчдыг үнэмлэхжүүлэх, зэрэг олгох ажлыг Монголын мэргэжлийн холбоодтой хамтарч хийх

г. Бүх жуулчны баазуудыг боловсон бие засах газар, халуун ус, душтай болгох шаардлагыг тавьж хэрэгжүүлэх

д. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд аттестатчлалыг 2 жил тутам явуулах

### **3.5. Аялал жуулчлалын гол бүсүүдэд дэд бүтэц хүргэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

а/ Увс, Хяргас нуурын эрэгт боловсон ОО, шүршүүр бүхий байгууламжийг барьж байгуулах

б/ Аялал жуулчлалын бүс нутгууд болон төв зам дагуу түр буудаллах цэгүүд байгуулах газрыг иргэн, ААН-д нээлттэй төсөл сонгон шалгаруулах замаар олгож, дэмжлэг үзүүлэх

в/ Боршоо боомтыг ОУ-ын статустай болгож, барилга байгууламжийг барих асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх

г/ Дэглий цагаан нисэх онгоцны буудлын нислэгийн зурвасыг өргөтгөж ОУ-ын нислэг шууд хүлээж авах боомт нисэх буудал болгох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх

д/ Увс нуур чиглэлийн авто замыг сайжруулан засах

### **3.6. Аялал жуулчлалын салбарын хууль эрх зүйн байдал, хөрөнгө оруулалтын дэмжлэг, боловсрол, сургалтын чадавхийг сайжруулах**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

а/ Аялал жуулчлалын салбарт ажиллаж байгаа донор байгууллагуудтай сүлжээ үүсгэх, нөөц бололцооны талаарх мэдээлэл солилцох, дэмжлэг хүсэх

б/ Харилцаа холбоогоо өргөтгөх, хөрөнгө оруулагчид хайх

в/ Улаанбаатар хотын түр компануудтай түншлэл бий болгох, хамтран ажиллах арга замаа тодорхойлох

г/ Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллах

### **Увс аймгийн хувьд дараах эвент арга хэмжээг зохион байгуулах боломжтой.Үүнд:**

- Ойрад түмэн язгуур урлагийн ОУ-ын наадам
- Тэмээний баяр /Мөсний баяр –Хяргас нуур 03 дугаар сарын эхний 7 хоног/
- Увс нуур цомын барилдаан /Бүх ноолдан 09 сарын 15-20 хооронд/
- Чацарганы баяр /09 сарын сүүлийн 7 хоногт/
- Увс нуурын ханш нээх баяр /Цөн түрэх, Шувууны баяр 05 сарын 10-15/
- Ойрад түмний Нүүдэлчдийн соёлын нэг өдөр /үндэстэн ястны онцлогийг харуулсан гэр, хувцас гоёл, ахуйн эд хэрэглээ, цагаан идээ боловсруулах, арвайн гурил хийх, , эсгий хийх, бугуйл, чөдөр, ногт зангидах, малын түүхий эд боловсруулах, гэр барих, нүүдэл хийх, хурим найрын ёслол гэх зэрэг монголын ахуй соёл, өв уламжлалыг харуулсан цогц арга хэмжээ/

- Өндөр уулын авиралт
- Усан замын аялал
- Дарвуулт болон сэлүүрт завины уралдаан
- Спорт адал явдалт аяллын аймаг, бүс, улс, ОУ-ын тэмцээн

#### ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

##### 4.1 Шалгуур үзүүлэлт

Д/ д	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2017 он 08 сар	Хүрэх түвшин, он			
			2018	2019	2020	2021
1	Хилийн боомтоор нэвтэрсэн нийт зорчигчийн тоо үүнээс	49515	51000	53000	55000	68000
	- гадаад	32015	33000	34400	35000	38000
	- монгол	17500	18000	18600	20000	30000
2	Байршуулах хэрэгсэлд байрласан гадаад жуулчдын тоо	4100	5000	6000	7500	10000
3	Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд Үүнд:					
	- жуулчны бааз	8	9	10	11	13
	- амралтын газар	3	3	3	4	4
	- рашаан сувилал	3	3	3	4	4
	- гэр бааз	4	5	6	7	8
	- зочид буудал	7	7	8	8	9
	- гэст хаус/ дэн буудал	2	3	3	4	4
	- ресторан	5	5	5	6	6
	- ресторан, зоогийн газар	5	5	6	7	7
	- паб, кафе	4	5	6	7	7
4	Орон нутагтаа зохион байгуулсан эвент арга хэмжээ	5	6	7	7	7
5	Олон улсын үзэсгэлэн арга хэмжээнд					

	оролцсон байдал					
	- Арга хэмжээний тоо	3	4	4	4	4
	- ААН, иргэний тоо	45	50	60	65	70
	- Бүтээгдэхүүн үйлчилгээ	8	10	11	12	15
6	Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэдэг нөхөрлөлийн тоо	6	14	25	30	35
7	Орон нутгийн төсвөөс аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ, сая.төг	100.0	200.0	230.0	60.0	70.0

#### 4.2 Хүрэх үр дүн

№	Зорилтууд	1-р үе шат /2017-2019/	2-р үе шат /2020-2021/
1	Байгаль, түүх соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, аялал жуулчлалын төв байгуулж хөгжүүлэх	Аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулахад чиглэсэн Мөсний баяр, Шувуу ажиглаж цөн түрх аяллыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж эвент арга хэмжээ болгосон байна.	Аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг өргөжүүлэн хөгжүүлж Улсын хэмжээнд зохион байгуулна.
		Уулын болон ширүүн урсгалт голуудыг түшиглэсэн адал явдалт спорт аяллын төрөлтэй болсон байна.	Томоохон нууруудыг түшиглэсэн усан аяллан төрөлтэй болсон байна.
		Хөрш орнуудад хил дамнасан аялал жуулчлалын маршруттай болсон байна.	Хил дамнасан маршрутаар аялах жуулчдын тоо нэмэгдсэн байна.
		Хөрш зэргэлдээ улс орнуудад “Увс аймгийн өдөр” арга хэмжээг зохион байгуулж аймаг орон нутгаа сурталчилсан байна.	Хөрш орнуудаас ирэх аялагч жуулчдын тоо нэмэгдсэн байна.
		Түүх соёлын өвийн судалгаа, шинжилгээг нэмэгдүүлж, хадгалалт хамгаалалтыг сайжруулсан байна.	Соёлын өвийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнтэй болсон байна.
		Аймгийн төвд болон нисэх онгоцны буудалд Аялал жуулчлалын мэдээллийн төвийг байгуулан гадаад, дотоодын жуулчдыг мэдээллээр хангаж, мэдээллийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.	
Баруун Монголын өв соёлыг сурталчлан таниулах, эвент арга	“Баруун монголын язгуур урлагийн наадам”, “Чацарганы баяр”, “Увс нуур цом”-ын барилдааныг зохион байгуулж Үндэсний хэмжээний эвенттэй болсон байна.		

2	хэмжээ болгон хөгжүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж өрхийн орлогыг нэмэгдүүлэх	Нутгийн иргэдийн аялал жуулчлалын талаарх мэдлэг, боловсролыг нэмэгдүүлж аялал жуулчлалын өрхийн түвшний бүтээгдэхүүн үйлчилгээтэй болсон байна.	Нутгийн иргэдийн бий болгосон бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан дэмжиж, зах зээлд нэвтрүүлж, Төсөл хөтөлбөрт хамруулсан байна.
		Сум бүр өөрийн онцлогт тохирсон эвент арга хэмжээг зохион байгуулж эхлэх	Эвент арга хэмжээнүүд тогтмолжсон байна.
3	Аялал жуулчлалын маркетинг сурталчилгааны ажлыг хөгжүүлэх орон нутгийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, сайжруулах	Жил бүр Улаанбаатар хотноо зохион байгуулагддаг ИТМ болон хөрш зэргэлдээ орнуудад зохион байгуулагддаг аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт оролцож аймаг орон нутгаа сурталчилсан байна.	
		Аймгийн аялал жуулчлалын мэдээллийн сүлжээг сайжруулан, аймаг орон нутгийн танилцуулга, ном, брошур, гарын авлагыг англи, орос, хятад хэл дээр гаргасан байна.	Жуулчдын тоо нэмэгдсэн байна
		Аймгийн байгалийн үзэсгэлэнт газар болон түүх соёлын дурсгалыг харуулсан баримтат кино ведио сан, фото зурагтай болсон байна.	Аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдсэн байна
		Аялагч жуулчдын эрүүл аюулгүй орчинд аялах нөхцлийг сайжруулах нөхцөл боломжийг судлах	Жуулчдад зориулсан эрүүл мэндийн анхны тусламж үйлчилгээний бүтээгдэхүүнтэй болсон байна.
		Гадаад болон дотоодын аялагч нарт аймгийн аялал жуулчлалын мэдээллийг бүрэн илэрхийлж чадах хэмжээний гар утасны аппликэйшин болон платформ бүтээх, платформтой болсон байна.	
4	Хүний нөөцийг чадавхжуулах, үйлчилгээний байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	Аялал жуулчлалын мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулж англи, орос хэлний мэдлэгтэй болгон чадавхжуулсан байна.	Хөрш орнуудтай хамтран аялал жуулчлалын мэргэжилтэнг чадавхжуулан суралцуулж тэтгэлэгт хөтөлбөрт хамруулсан байна.
		Улаангом Политехник коллежийг түшиглэн мэргэжлийн боловсон хүчнийг сургалтанд хамруулж эхлэнэ.	Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний ажилтан чадавхжиж мэргэжлийн үнэмлэхтэй болсон байна.
		Монголын мэргэжлийн холбоодтой хамтран Зочлох үйлчилгээний салбарын ажилтнуудыг чадавхжуулж, чадварыг нь үндэслэн зэрэглэл тогтоож үнэмлэх, гэрчилгээ олгосон байна.	Аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч, үйлчилгээний ажилтан чадавхжиж хөгжсөн байна.
		Бүх жуулчны баазуудыг боловсон бие засах газар, халуун ус, душтай болгох шаардлагыг тавьж хэрэгжүүлэх	ОУ-ын стандартад нийцсэн ариун цэврийн байгууламж, шүүршүүртэй болсон байна.
		Олон улсын байгууллага, хөрш зэргэлдээ гадаад улс орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн 2-3 төсөл хөтөлбөрт хамрагдан хэрэгжүүлсэн байна.	

5	Аялал жуулчлалын гол бүсүүдэд дэд бүтэц хүргэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	Аялал жуулчлалын гол бүс болох Увс нуурын эрэгт боловсон ариун цэвэр, халуун ус шүршүүрийн байгууламжийг барьж байгуулсан байна.	
		Боршоо боомтыг ОУ-ын статустай болгох, барилга байгууламжийг барих асуудлыг шийдвэрлүүлэх	Боршоо боомт ОУ-ын статустай болох эхлэл тавигдсан байна.
		Дэглийн цагаан нисэх онгоцны буудлын нислэгийн зурвасыг өргөтгөж ОУ-ын нислэг шууд хүлээн авах боомт, нисэх буудал болгох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлүүлэх	
		Уулын адал явдалт аялал сонирхогчдод зориулан аялал жуулчлалын гол зам чиглэлийн дагуу түр буудаллах цэгүүд, боловсон ариун цэвэрийн байгууламж, хогийн цэгүүдийг байгуулсан байна.	
		Увс нуур чиглэлийн авто замыг сайжруулан зассан байна	Сайжирсан авто замтай болсон байна
6	Аялал жуулчлалын салбарын хууль эрх зүйн байдал, хөрөнгө оруулалтын дэмжлэг, боловсрол, сургалтын чадавхийг сайжруулах	Аялал жуулчлалын салбарт ажиллаж байгаа донор байгууллагуудтай сүлжээ үүсгэх, мэдээлэл солилцох, дэмжлэг хүсэх	Донор байгууллагуудтай ажиллах хамтын ажиллагаа тогтворжсон байна.
		Харилцаа холбоогоо өргөтгөсөн байна	Харилцаа холбоо өргөжиж хөрөнгө оруулагчдыг татсан байна.
		Улаанбаатар хотын түр компануудтай түншлэл тогтоож, хамтран ажиллах арга замаа тодорхойлсон байна.	Хамтын ажиллагаа сайжирч жуулчдын тоо нэмэгдсэн байна.
		Орон нутгийн ААН-үүд хэрэгжүүлэх боломжтой аялал жуулчлалын үйлчилгээтэй холбоотой тохирсон технологиудыг судлаж нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн байна.	Аялал жуулчлалын үйлчилгээнд тохирсон технологийг нэвтрүүлсэн байна.
Аялал жуулчлалын салбарт	Аялал жуулчлалын салбарын дэд бүтэц, үйлчилгээний чанар хүртээмж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар гадаад жуулчдын тоо 28000, дотоодын жуулчдын тоо 20000-д хүрсэн байна.	Аялал жуулчлалын салбарын дэд бүтэц, үйлчилгээний чанар хүртээмж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар гадаад жуулчны тоо 38000, дотоодын жуулчдын тоо 30000-д хүрсэн байна.	
	Аялал жуулчлалын салбарт жуулчны оруулах нийт орлого 8 тэрбум төгрөг болно.	Аялал жуулчлалын салбарт жуулчны оруулах нийт орлого 10 тэрбум төгрөгт хүрнэ.	

**ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ,  
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ**

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Аймгийн ЗДТГ хариуцан зохион байгуулна.
2. Хэрэгжилтийг БОАЖГ, БСУГ, ГХБХБГ, сумдын ЗДТГ зохион байгуулж үр дүнг бүтэн жилээр аймгийн ЗДТГ-т тайлагнана.
3. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ХШҮДАХ, БОАЖГ нь жил бүр хяналт шинжилгээ үнэлгээ хийж, жилийн эцэст үр дүнг ИТХ-д тайлагнана.

**ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

1. Улсын төсөв
  2. Орон нутгийн төсөв
  3. Аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо нөхөрлөл, иргэний өөрийн хөрөнгө
  4. Дотоодын болон олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, тусламж, урт хугацааны зээл
  5. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив зэрэг болно.
- Улсын болон орон нутгийн төсвөөс гаргах хөрөнгийг аймаг, сумын тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж санхүүжүүлнэ.

**Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэл, түүний удирдлага**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд доорх эрсдэл тохиолдож болохыг тооцно:

- Нийтийг хамарсан өвчин, байгаль, цаг уурын гамшигт үзэгдэл
- Олон улсын болон аймаг орон нутгийн эдийн засгийн хямрал
- Аймаг орон нутгийн болон бүс нутгийн улс төрийн нөхцөл байдал

Дээр дурьдсан эрсдлийн удирдлагын арга механизмыг энэхүү хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны хүрээнд байнга боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.

.....оОо.....





**2017-2021**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн/үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Хугацаа	Орон нутгийн төсөв / сая.төг /				
							2017	2018	2019	2020	2021
1	2	3	4	5	6	7					
<b>Зорилт 1. Байгаль, түүх соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, аялал жуулчлалын төв байгуулж хөгжүүлэх</b>											
1.1	Аялал жуулчлалын мэдээллийн төвийг ашиглалтанд оруулах, үйл ажиллагааг тогтмолжуулах	Мэдээллийн төв ашиглалтанд орсон байна.	Үйл ажиллагаа тогтмолжсон байна.	БОАЖГ	ЗДТГ	2017	30.4				
	Байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалуудын мэдээллийн санг шинэчлэн баяжуулж сан бүрдүүлэх	Мэдээллийн санг бүрдүүлж эхэлсэн байна.	Мэдээллийн сан бүрдсэн байна.	БОАЖГ	ОНС Музей	2017-2021					
1.2	Дэглий цагаан нисэх онгоцны буудал дээр аялал жуулчлалын мэдээллийн төв ажиллуулах	Мэдээллийн төвийг байгуулсан байна	Төвийн үйл ажиллагаа тогтмолжсон байна.	БОАЖГ	Дэглий цагаан нисэх онгоцны буудал	2017	8.0				
1.3	Рашаан сувилалын хөгжүүлэх зорилгоор амралт рашаан сувилал байгуулж болох газруудыг тогтоож, рашааны найрлага, шинж чанарын судалгааг хийх / 10 рашаан /	Рашааны найрлага шинж чанар судлагдсан байна.	Батлагдсан стандартын дагуух судалгааны баримт бичигтэй болсон байна.	БОАЖГ	УЦУОШГ, сумдын ЗДТГ	2018-2019		1.0	1.0		
1.4	Аймгийн "Аялал жуулчлалын холбоо" шинэчлэн байгуулах	Аялал жуулчлалын холбоо байгуулагдсан байна.	Аялал жуулчлалын холбооны үйл ажиллагаа эхлэсэн байна.	БОАЖГ	ЗДТГ	2018					
1.5	Аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасгах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх Мөсний баяр, Тэмээний баярыг /03 сарын эхний 7 хоногт / зохион байгуулах	Өвлийн улиралд явуулах бүтээгдэхүүн үйлчилгээтэй болно.	1-2 эвенттэй болно.	БОАЖГ	Сумдын ЗДТГ	Жил бүр		1.5	1.5	1.5	
1.6	Адал явдалт спорт аяллыг хөгжүүлэх / нууранд завиаар аялах, фото сафари аялал /	Шувуу ажиглах, Загасчлах аялал хөгжинө.	Аялал бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдэнэ.	БОАЖГ	ЗДТГ БТСГ	2018-2021		2.0			
1.7	Аймгийн төв болон хот орчмын	Тойрон аяллын	Батлагдсан	БОАЖГ		2018-2021		0.5	0.5	0.5	

	тойрон аяллын маршрутыг батлан гаргаж сурталчлах, танин мэдэхүйн аяллыг хөгжүүлэх, хүүхэд залуучууд, аж ахуйн нэгжүүдийн дунд тойрон аяллын экскурсыг зохион байгуулах	экскурс зохион байгуулагдаж, хүүхэд залуучууд, аж ахуй нэгжүүдийн оролцоо нэмэгдсэн байна.	маршруттай, хүүхэд залуучуудын аяллын танин мэдэхүйн боловсрол нэмэгдсэн байна.		ХГБХГ, БСУГ						
1.8	Түүх соёлын өвийн судалгаа, шинжилгээг нэмэгдүүлэх, хадгалалт хамгаалалтын асуудлыг сайжруулах,	Түүх соёлын өвийн судалгаа шинжилгээ хийгдэж, хадгалалт хамгаалалт сайжирсан байна.	Судалгааны материалтай болсон байна.	ОНС Музей	БСУГ БОАЖГ	2018-2021		5.0	5.0	5.0	
	Түүхэн газруудад соёлын өвийн аялал жуулчлал болон түүхэн аяллыг хөгжүүлэх /Дамбийжаагийн төрсөн газар, Галдан бошигтын тариг, Ю. Цэдэнбалын төрсөн газар, Төгс буянтын хийд, Харлаг бэйсийн сүм, Чандмань Улаан уул г.м/	Түүхэн аяллын маршруттай болсон байна.	Түүхийг сурталчилж таниулах ажил сайжирсан байна.	ОНС Музей БОАЖГ	Сумдын ЗДТГ	2018-2021					
<b>Зорилт 2.</b> Баруун Монголын өв соёлыг сурталчлан таниулах, эвент арга хэмжээ болгон хөгжүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж тэдний амьжиргааг дээшлүүлэх											
2.1	<ul style="list-style-type: none"> <li>- “Ойрад түмэн язгуур урлагийн Олон улсын наадам” /08.03-08.04 өдөр/,</li> <li>- “Чацарганы баяр” /09 сарын сүүлийн долоо хоног/,</li> <li>- “Увс нуур цом” -ын /09.15-09.20/ барилдааныг зохион байгуулж үндэсний хэмжээний эвент болгох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэх</li> </ul>	Үндэсний хэмжээний эвенттэй болсон байна.	Эвенттэд оролцох жуулчны тоо нэмэгдсэн байна.	ЗДТГ БОАЖГ АЖ холбоо	БТСГ ХХААГ БСУГ	Жил бүр	15.0	10.0 5.0 5.0	10.0 5.0 5.0	10.0 5.0 5.0	

	“Ойрад түмний Нүүдэлчдийн соёлын нэг өдөр” арга хэмжээг зохион байгуулах /08 сарын 2 дахь 7 хоногт /	Уламжлалт ахуй соёлоо таниулах	Жуулчдын тоо нэмэгдэнэ.	ЗДТГ БОАЖГ	Сумдын ЗДТГ Ойрад ХЖТ			5.0	5.0	5.0	
2.2	НИТАЖ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нөхөрлөлүүдийг чадавхжуулах, сургалт зохион байгуулах (гар урлал, сувинер нь бүтээгдэхүүн, хөтөч г.м), ЖДҮ-ийн зээлд хамруулан дэмжих, орлого нэмэгдүүлэх	Орон нутагт чадавхжсан нөхөрлөлүүдтэй болсон байна.	НИТАЖ-ийн үйл ажиллагаа сайжирсан байна.	БОАЖГ УТХГН-ын хамгаалалтын захиргаа	Сумдын ЗДТГ	Жил бүр		2.0	1.0	1.0	
2.3	Жуулчдын олноор хүрэлцэн очдог газруудад мэдээллийн самбар, маршрут чиглэлийг заасан замын тэмдэг тэмдэглэгээг англи, орос, монгол хэл дээр хийж байрлуулах	Мэдээллийн самбар, маршрут чиглэлийг заасан замын тэмдэг, тэмдэглэгээ англи, монгол хэл дээр хийгдсэн байна.	ОУ-ын стандартад нийцсэн замын тэмдэг тэмдэглэгээтэй болсон байна.	ЗДТГ БОАЖГ	УТХГН-ын хамгаалалтын захиргаа, Жуулчны бааз,	2018		10.0	10.0	5.0	
2.4	Орон нутгийн онцлогийг харуулсан бүтээгдэхүүний дизайн, үйлдвэрлэл, менежментийг сайжруулах, сурталчлах (аймаг орон нутгийн онцлогийг харуулсан шилдэг сувинерын бүтээгдэхүүнийг тодорхойлох)	Бүтээгдэхүүний нэр төрөл чанар сайжирсан байна.	Орон нутгийн онцлогийг харуулсан олон нэр төрөл, загвар дизайн бүхий бүтээгдэхүүнтэй болно.	ХХААГ БОАЖГ	ААН-үүд	2018-2021		2.0	1.0	1.0	
	Жуулчны бааз, амралт сувилалын газруудад нэмэлт үйлчилгээг нэвтрүүлэх (ардын урлаг соёлын тоглолт, тэмцээн уралдаан, явган аялал г.м )	Үйлчилгээний чанар сайжирсан байна.	Жуулчдын сэтгэл ханамж нэмэгдсэн байна.	БОАЖГ АЖ холбоо	ААН-үүд	2018-2021					
<b>Зорилт 3. Аялал жуулчлалын маркетинг сурталчилгааны ажлыг хөгжүүлэх, орон нутгийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, сайжруулах</b>											
3.1	Гадаад болон дотоодын аялагч нарт аймгийн хэмжээний аялал жуулчлалын мэдээллийг бүрэн илэрхийлж чадах хэмжээний гар утасны аппликэйшин болон	Аялал гар утасны аппликэйшин болон платформтой болсон байна.	Хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	БОАЖГ		2019				5.0	

	платформ бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх				ЗДТГ						
3.2	Аймгийн байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газруудад аяллын баримтат кино хийж видео сан бүрдүүлэх, фото зураг авах	Баримтат кино, видео сан, фото зурагтай болсон байна.	Аялал жуулчлалын мэдээллийн сан нэмэгдэнэ.	ЗДТГ БОАЖГ	БСУГ	2018-2019	10.0	5.0			
3.3	Жил бүр зохион байгуулагддаг аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт үе шаттай оролцох	Аймаг орон нутгаа сурталчлан оролцсон байна.	Оролцоо болон аялагч жуулчдын тоо нэмэгдсэн байна.	ЗДТГ АЖ холбоо	БОАЖГ	Жил бүр	15.0	8.0	30.0 Түнш аймаг	5.0	
3.4	Аймгийн аялал жуулчлалын цахим сайтыг сайжруулан хөгжүүлэх, аймаг орон нутгийг танилцуулсан гарын авлага, хөтөч номыг "Guide book" англи, орос, хятад хэлээр гаргах	Аймаг орон нутгийг танилцуулсан хөтөч ном англи, орос, хятад хэл дээр гарсан байна.	Гадаадын жуулчдын мэдээллийг авах нөхцөл сайжирсан байна.	БОАЖГ	АЖ холбоо УТХГНХЗ	2018- 2019	7.0	3.0	3.0	3.0	
3.5	Хөрш зэргэлдээ ОХУ-ын Тува улсын нийслэл Кызыл хотноо болон Хятад улсын зарим хотноо "Увс аймгийн өдөр"-ийг зохион байгуулах	Аймаг орон нутгаа сурталчлан оролцсон байна.	Жуулчдын тоо нэмэгдэнэ.	БОАЖГ	ЗДТГ БСУГ	2017-2021	35.0	15.0	20.0	20.0	
3.6	Хөрш зэргэлдээ ОХУ-ын хотуудын аялал жуулчлалын компаниудыг өөрийн аймагт урьж хамтарсан томоохон судалгааны аяллыг зохион байгуулах /Увс нуур судлал/	Туршлага судалж, мэдээллийн сүлжээ өргөжсөн байна.	Хамтын ажиллагаа нэмэгдсэн байна.	БОАЖГ	ЗДТГ АЖ холбоо	2018		10.0			
3.7	Сүм бүрт жуулчдын аюулгүй байдлыг хангах зөвлөлийг байгуулах, эрүүл мэндийн төвүүдэд мэдээллийн самбар байршуулах (Эрүүл мэнд, цагдаа, онцгой байдал г.м)	Жуулчдын эрүүл аюулгүй орчинд аялах нөхцөл бүрдэнэ.	Жуулчдад хүрч ажилласан байна.	ЗДТГ БОАЖГ	Сүмдын ЭМТ Цагдаа ОБГ	2018-2021		3.0			
3.8	Жуулчдын даатгалын тогтолцоог хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Жуулчдын аюулгүй эрсдэлгүй аялах нөхцлийг бүрдүүлсэн байна.	Нийгмийн даатгалын тогтолцоог хэрэгжүүлсэн байна.	ЗДТГ НДХ	БОАЖГ Гааль Даатгалын компаниуд	Жил бүр					
3.9	Аймгуудын орон нутгийн хэвлэл мэдээллийн албатай гэрээ байгуулан өөрийн аймаг орон нутгийг сурталчилсан танилцуулга ведио, шторкыг	Мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.	Дотоодын жуулчдын тоо нэмэгдсэн байна.	АЗДТГ Хэвлэл мэдээллийн алба	БОАЖГ	2018-2021		3.0	3.0	3.0	

	явуулах												
3.10	Байгалийн унаган төрх байдлыг алдагдуулахгүйгээр байгаль экологит ээлтэй “ул мөргүй” аялах аяллыг сурталчлах, дэмжих	Байгалийн унаган төрх хамгаалагдана.	Ул мөргүй аялал хөгжсөн байна.	БОАЖГ	Сумдын ЗДТГ	2018-2021							
<b>Зорилт 4. Хүний нөөцийг чадавхжуулах, үйлчилгээний байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх</b>													
4.1	Аялал жуулчлалын үйлчилгээний салбарын ажилчдыг үе шаттайгаар чадавхжуулах, аялал жуулчлалын аймгийн нэгдсэн зөвлөгөөнийг 2 жил тутам зохион байгуулах, үйлчилгээний ажилчдыг үнэмлэхжүүлэх	Үйлчилгээний ажилчид чадавхжсан байна.	ААН-ийн оролцоо нэмэгдэж хамтын ажиллагаа сайжирна.	БОАЖГ	ЗДТГ ХАУТанхим	2018-2021		5.0			5.0		
4.2	Улаангом Политекник коллежийн аялал жуулчлалын чиглэлээр суралцагч оюутнуудыг зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан чанартай бэлтгэх	Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдсэн байна.	Үйлчилгээ сайжирсан байна.	УПТКоллеж	ХД сургууль БОАЖГ	2017-2021							
4.3	Аялал жуулчлалын мэргэжилтнүүдийг ОХУ, Тайвань, Энэтхэг зэрэг улсуудад хэлний болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд үе шаттайгаар хамруулах	ОХУ, Тайвань, Энэтхэг улстай хамтран ажиллах арга замаа тодорхойлсон байна.	Тус улсад 1-3 мэргэжилтэн дадлагдажүүлсэн байна.	ЗДТГ	БОАЖГ	2017-2021		5.0	5.0	5.0			
4.4	Зочид буудал, амралт сувиллын газар, жуулчны бааз, баар, ресторан, үйлчилгээний төвүүдийн үйлчилгээний чанарын зэрэглэл стандартын шалгалтыг хийх, зөвлөн туслах	Үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар сайжирсан байна.	Стандартыг мөрдсөн байна.	МХГ	БОАЖГ	2017-2021							
4.5	Жуулчдад үйлчилдэг жолооч нарыг давтан сургах, бүртгэлжүүлэх, гэрчилгээжүүлэх	Жолооч нарыг бүртгэлжүүлж гэрчилгээжүүлсэн байна.	Аюулгүй байдал хангагдсан байна.	АТГ	ЗЦГ	2017-2021							
4.6	Зочид буудлын хүлээлгийн танхимд аймаг орон нутгийн аялал жуулчлалын мэдээллийн самбар болон сувинер, бренд бүтээгдэхүүн борлуулах цэгтэй	Мэдээллийн самбар, бүтээгдэхүүн борлуулах цэгтэй болсон байна.	Мэдээллээр хангагдсан байна	БОАЖГ	АЖХолбоо ААН-үүд	2019							

	болох												
<b>Зорилт 5. Аялал жуулчлалын гол бүсүүдэд дэд бүтэц хүргэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх</b>													
5.1	Увс, Хяргас нуурын эрэгт боловсон ОО, Шүршүүр бүхий байгууламжийг барьж байгуулах	Увс нуурын эрэгт боловсон ОО, шүршүүр бүхий байгууламж баригдсан байна.	Байгууламжтай болсон байна.	ЗДТГ	БОАЖГ УНАСУТХГ-ын ХЗ	2017-2021		100.0	70.0				
5.2	Аялал жуулчлалын зориулалтаар Аймгийн ГЗБТ-д тусгагдсан газруудыг ААН-үүдэд нээлттэй төсөл сонгон шалгаруулах замаар олгож дэмжлэг үзүүлэх	Газрын сонгон шалгаруулалтаар олгосон байна.	Жуулчны бааз, амралт сувилалын газрууд байгуулагдсан байна	БОАЖГ ГХБХБГ	Сумын ЗДТГ	2017-2021							
5.3	Гол зам дагуу түр буудаллах цэгүүдийг тогтоож төсөл сонгон шалгаруулах замаар иргэн, ААН-д олгох	Газрын сонгон шалгаруулалтаар олгосон байна.	Бааз, түр буудаллах цэгүүд байгуулагдсан байна.	БОАЖГ	ГХБХБГ	2017-2021							
5.4	Боршоо боомтыг ОУ-ын статустай болгож, барилга байгууламжийг барих асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	Боршоо боомтыг ОУ-ын статустай болгож барьж байгуулах ажлыг эхлүүлсэн байна.	Жуулчдын тоо нэмэгдсэн байна.	ЗДТГ Гаалийн газар	ЗДТГ	2017-2021							
5.5	Дэглий цагаан нисэх онгоцны буудлын нислэгийн зурвасыг өргөтгөж ОУ-ын нислэг шүүд хүлээж авах боомт нисэх буудал болгох, Үрэмч-Улаангом-Кызыл чиглэлийн шинэ нислэгийг нээх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	Нисэх онгоцны буудлын нислэгийн зурвасыг өргөтгөсөн байна.	ОУ-ын нислэг хүлээж авдаг болсон байна.	ИНЕГ ЗДТГ	Дэглий цагаан нисэх онгоцны буудал	2017-2021							
5.6	Бөөрөг дэл, Алтан элс орчимд холбоо харилцааны дахин дамжуулах станц байгуулах					2019			10.0				
<b>Зорилт 6. Аялал жуулчлалын салбарын хууль эрх зүйн байдал, хөрөнгө оруулалтын дэмжлэг, боловсрол, сургалтын чадавхийг сайжруулах</b>													
6.1	Аялал жуулчлалын салбарт ажиллаж байгаа донор байгууллагуудтай сүлжээ	Донор байгууллагуудтай сүлжээ үүсгэж,	Хамтын ажиллагаа өргөжсөн байна.	ЗДТГ БОАЖГ	АЖ холбоо	2017-2021							

	үүсгэх, нөөц бололцооны талаарх мэдээлэл солилцох, дэмжлэг хүсэх	туршлага судалсан байна.									
6.2	Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх нийтлэг журам боловсруулж батлуулах	Журамтай болсон байна.	Хэрэгжилтийг хангасан байна.	БОАЖГ	ЗДТГ	2018					
6.3	Улаанбаатар хотын тур компануудтай түншлэл бий болгох, хамтран ажиллах арга замаа тодорхойлох	Тур компанудтай хамтран ажиллаж хамтын ажиллагаа тогтмолжсон байна.	Жуулчдын тоо нэмэгдэнэ.	БОАЖГ	АЖ холбоо	2017-2021					
6.4	Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллах (Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөр )	Хамтын ажиллагаа сайжирсан байна.	Аялал жуулчлалын үйл ажиллагаа тогтворжсон байна.	ЗДТГ БОАЖГ	(GIZ)- төсөл хөтөлбөр	2018-2020					

.....оОо.....